

## ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН 2010 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2010 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

### Оршил

Тус газар нь 2010 онд нийт 21 ажилтны ажлын байртайгаар үйл ажиллагаа явуулахаас газрын дарга, орлогч дарга тус бүр нэг, ахлах хянан шалгагч 3, хянан шалгагч 12 буюу нийт 17 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр ажиллаа.

Тайлант хугацаанд нэг хянан шалгагч гадаад улсад урт хугацаанд суралцахаар, өөр албан тушаалд шилжих үндэслэлээр нэг хянан шалгагч тус тус чөлөөлөгдөж нэг ахлах хянан шалгагч ажлаас халагдсан дүнтэй байна. Тэдгээрийн оронд 2 хянан шалгагч уг газарт шинээр ажилд орсон байна.

Тайлант хугацаанд тус газар нь Хорооноос баталсан “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 115 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан “Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн төлөвлөгөө”, “Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны 2010 онд хийх ажлын төлөвлөгөө”, Ерөнхий менежертэй байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хүрээнд төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг хангаж ажиллаа.

Тус газар нь 2010 он 1 дүгээр сард газрын нийт ажилтнуудтай зохих үр дүнгийн гэрээг байгуулж ажилтнуудын тус бүрийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн ажилласан болно.

Тайлант хугацаанд тус газрын зохицуулалт хяналтад арилжаа эрхлэх байгууллага 1, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага 1, мэргэжлийн оролцогч байгууллага 51, хувьцаат компани 336 ширхэг байгууллага байсан болно.

Үнэт цаасны зах зээлийн төлөв байдлын хувьд санхүү, эдийн засгийн хямралт байдал аажмаар зөөлөрч, үнэт цаасны арилжааны идэвхи дээшлэн, зарим үнэт цаасны ханшийн өсөлт ажиглагдсан жил байлаа.

Гэвч зах зээлийн идэвхжил нь нийт зах зээлийг бүрэн хамарч чадаагүй, зах зээлийн бүтэц, зохион байгуулалтын хөгжил сул, тусгай зөвшөөрл бүхий мэргэжлийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээний чанар доголдолтой, зах зээл дэх бүртээгдэхүүний чанар болон эрэлт нийтлэг байдлаар сул хэвээр байлаа. Зах зээлийн үнэлгээ огцом өссөн дүнтэй байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээгээр тус улын зах зээлийн хувь, хэмжээ бага хэвээр байлаа.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан тус газар нь тайлант хугацаанд зах зээлийн хөгжлийн суурь хүчин зүйл болох эрх зүйн орчныг шинэчлэх, оролцогчдын санхүүгийн

чадавхийг дээшлүүлэх, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх болон гарч буй зөрчил, дутагдалыг арилгах чиглэлээр түлхүү анхаарч ажилласан болно.

**Үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:**

Тайлант хугацаанд тус газраас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, түүнтэй холбоотой холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулах, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн төслийг боловсруулах бэлтгэлийг хангах чиглэлээр толгойлон ажиллаа.

Дээрх ажлын үр дүнд тус газраас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг уг төсөлтэй холбоотойгоор бусад хууль оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамт боловсруулж дуусаад байна. Тодруулбал, Эрүүгийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Даатгалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт боловсруулаад байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийн хувьд Хорооны гишүүн Д.Дүгэржав ахлан ажилласан бөгөөд хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулж чадсан болно. Хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай байгаа нэгдсэн хоёр журмын төслийг боловсруулан, холбогдох байгууллагаас санал аван зохих байгууллагаар хамтран батлуулахаар ажиллаж байна.

Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн тухайд өмнө тус Хорооноос боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлээд байсан төслийг эргүүлэн авч Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллан хуулийн төслийг боловсруулж дуусаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн бариулаад байна.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн тухайд хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын эрх зүйн статусыг тодорхой болгох, тэдгээрт тавих шаардлага, үйл ажиллагааны зарчмыг тодорхой болгох, гадаадын хөрөнгө оруулалтын байгууллага Монголд үйл ажиллагаа явуулах асуудлыг хуульчлах чиглэлээр хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж, Сангийн яаманд санал авахаар хүргүүлээд байгаа.

Түүнчлэн, уг хуулийн төслийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд байгаа бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах чиглэл аван ажиллаж байна.

Эдгээрээс гадна, Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үнэлгээний тухай хуулийн төсөл, Зээлийн мэдээллийн тухай хуулийн төсөл, Тэмдэгтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг хуулийн төслүүдэд санал өгч ажиллаа.

Тэдгээрээс Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Үнэлгээний тухай хууль Улсын Их Хурлаар тус тус батлагдаад байна.

Дээрх ажлын хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчны талаар Улсын Их Хурлын гишүүдийн оролцоотойгоор, “Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг боловсруулах” асуудлаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирлага, үнэт цаас гаргагч, ХХК-иудын болон бусад байгууллагуудын удирдлагуудыг хамруулсан хэлэлцүүлгийг тус тус санаачлан зохион байгуулсан болно. Улмаар “Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Хуулийн төсөл боловсруулахаас гадна тайлант хугацаанд тус газраас Хөрөнгийн зах зээлийг ойрын хугацаанд буюу 2010-2012 онуудад хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг анх удаа Засгийн газрын түдшинд танилцуулан, хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулж чадлаа. Тодруулбал, тус газрын зүгээс боловсруулан хүргүүлснээр Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар 115 дугаар тогтоол батлагдан гарч, чингэснээр төрийн болон төрийн бус байгууллагын хүрээг бүрэн хамарсан, төрийн цогц бөгөөд харилцан уялдаа бүрхий арга хэмжээнүүд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх үндэс суурийг тавьж чадлаа.

Дээрх хуулийн төслийг боловсруулах ажлаас гадна 2010 оны дүнгээр мэргэжлийн оролцогч байгууллага, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаатай холбогдох үүссэн төрөл бүрийн харилцааг зохицуулахад чиглэсэн, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон Хорооны нийт 70 тогтоолыг гаргах үндэслэл, холбогдох баримт бичгийг хянаж бүрдүүлж ажиллажээ.

Тус Хорооноос бие даан батлан гаргах дүрэм, журмын тухайд 2010 онд нийт 5 журам, зааврын төсөл, нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан байх ба зохих журмын дагуу Хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн болон зохих журмын дагуу санал авч ажилласан байна. Үүнд:

1/ Хувьцаат компанийн хяналтын багцын хувьцааг эзэмшигчдээс дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хамт бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдаж авах санал заавал гаргах болон бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихээр аливаа этгээдээс сайн дурын үндсэн дээр энгийн хувьцаа худалдан авах санал гаргах харилцааг зохицуулах журмыг шинэчлэн боловсруулж, “Компанийг худалдан авах санал гаргах ажиллагааг зохицуулах журам”-ыг 2010 оны 5 дугаар сарын 28-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

2/ Компанийн зээлжих эрхийн зэрэглэл тогтоох ерөнхий аргачлалын төслийг олон улсын жишиг үзүүлэлтэнд тулгуурлан дотоодын онцлогт нийцүүлэн “Зэрэглэл тогтоох эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг боловсруулан Хорооны 2010 оны 3 дугаар сарын 24-ний хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

3/ Энэ журам батлагдсаны дагуу “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” болон “Зохицуулалтын байгууллагаас авах хөлсний тухай журам”-д өөрчлөлт оруулсан болно.

4/ “Харилцагчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах тухай журам”, “Үнэт цаас гаргагчаас үнийн мэдрэмжэй мэдээллийг үнэт цаасны зах зээл, олон нийтэд хүргэх тухай журам”, “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”, “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төслүүдийг боловсруулан Хорооны хуралдаанд танилцуулан холбогдох шийдвэрүүдийг гаргууллаа.

5/ Эцэст нь Монголбанкттай хамтран батлах “Санхүүгийн нэгдэлд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулан тус байгууллагад санал авахаар хүргүүлээ.

Дээрх ажиллагаанаас гадна тус газар нь тайлант хугацаанд Хорооны болон Үнэт цаасны хорооны эрх зүйн актуудын өмнөх жилд бүрдүүлсэн санг баяжуулж, эрх зүйн актад өөрчлөлт орох тухай бүр кодификаци хийхээс гадна тогтоол шийдвэрийн цахим товъёогийг тухай бүр хийж гүйцэтгэн нийтэд Хорооны веб хуудсаар дамжуулан мэдээлж ирлээ.

Мөн 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Ашигт малтмалын тухай хууль, улс орны эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ашигт малтмал, уул уурхайн чиглэлээр хөрөнгийн зах зээлтэй холбоотой тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаар Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Төрийн өмчийн хороо, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Ашигт малтмалын газартай уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр үнэт цаасны зах зээлийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, хувьцаат компанийг бүртгэх, бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулахгүйгээр хувьцааг арилжих ажлыг зохион байгуулах, нэгдсэн ойлголтод хүрэх ажлыг хийж гүйцэтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулан манай Хороо, ЭБЭХЯ, ТӨХ хамтран байгуулахаар тохиролцон ажиллаж байна.

#### **Дэд бүтэц, зах зээлийн зохицуулалтын талаар:**

Тайлант онд хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны цар хүрээ, өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч мэргэжлийн байгууллагуудын ашигт ажиллагааны төвшин, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилт зэрэг чиглэлд хяналт тавин, зохицуулалтын байгууллагын Хороонд хандан гаргасан хүсэлтэд зохих хариуг өгөх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг шинэчлэн олон улсын түвшинд хүргэх ажлын хүрээнд Хорооны зүгээс Төрийн өмчийн хороо, “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК зэрэг байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Арилжаа эрхлэх болон төлбөр тооцооны байгууллагын техник, технологи, программ хангамжийн шинэчлэл, үнэт цаасны хадгаламжийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт,

нууцлалын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх, улмаар үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн төвийг олон улсын төлбөр тооцоо, хадгаламжийн төвүүдтэй холбож, үйл ажиллагааг нь өргөжүүлэх талаар саналаа гарган Төрийн өмчийн хороонд хүргүүлсэн болно.

Үнэт цаасны газрын зүгээс зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн үр ашигтай байдлыг дэмжих зорилгоор 2010 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Хорооны арилжааны шимтгэлийн дүнгээс авч байсан 10 хувийн хөлсийг тэглэх саналыг Хорооны хуралдаанд танилцуулсны дагуу Хорооны хуралдаанаар зохих хөнгөлөлтийг үзүүлэх шийдвэр гаргасан болно.

МХБ-ийн арилжааны программд хэлцлийн худалдагч, худалдан авагчийн талд нэг данс, эсхүл холболтын данс байршдаг боломжийг хаах талаар өөрчлөлт оруулахаар шийдвэрлүүлээ.

АХБ-ны төслийн багтай хамтран арилжааны хяналтын программыг эхний байдлаар Access дээр боловсруулсан ба тус программ нь дараах үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан бичигдсэн болно. Үүнд:

- Авсан зарсан дансны дугаарууд ижил байх тохиолдлууд
- Сүүлийн 10 минутанд хувьцааны заралт болон нийлүүлэлтийг хийгээд байгаа брокеруудыг илрүүлэх
- Ямар хувьцаа эзэмшигч их хэмжээний арилжаа хийж байгааг илрүүлэх
- Ямар брокерийн компани ямар хувьцааг их хэмжээгээр арилжиж байгааг илрүүлэх
- Огт арилжаа хийгдэхгүй байж байгаад арилжаа хийж эхэлсэн компаниудыг илрүүлэх
- Хамгийн их, хамгийн бага үнийн дүнтэй, олон ширхэгээр хувьцаа арилжиж байгаа брокеруудыг илрүүлэх
- Хамгийн их, бага, дундаж ханшуудыг нийт хэлцлүүдийн хамт харах

Цаашид нэгдмэл сонирхолтой этгээдүүд болон холболтын дансаар хийгдсэн арилжаануудыг илрүүлж харах нэмэлт функцийг арилжааны хяналтын программд суулгах, төлбөр тооцооны байгууллагаас харилцагч данснуудын эзэмшигчдийн талаарх мэдээг гаргуулан авч мэдээллийн санд оруулж байх, шугаман болон лааны тосон графикаар ханшийн мэдээллийг авч болдог байх г. м. боловсронгуй болгох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

“Компанийн засаглалын 3 дугаар форум”-д 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр оролцож илтгэл хэлэлцүүлэг тавьж оролцлоо.

Арилжааны шууд хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийн чанарыг дээшлүүлэх зорилгоор хоёр хянан шалгагчийг томилон ажилуулсан ба зохиомлоор ханш өсгөж буй эсэхэд тухайлсан шалгалтыг хэрэгжүүлж дүнг Хорооны удирдлагад танилцуулж ажиллаа.

2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хорооны хуралдаанд сүүлийн дөрвөн улирлын хугацаанд дараалан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй болон мөнгөн хөрөнгийн гүйлгээг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа талаар харилцагчдаас нь өргөдөл гомдол ирүүлсэн компаниудын төлбөрийн чадварт учирч болзошгүй хүндрэлийг даван туулах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай байгаа талаар гаргасан газрын дүгнэлт, танилцуулгыг танилцуулж зарим брокер, дилерийн компаниуд болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад Хорооны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргууллаа.

Мэргэжлийн зуучлалын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа байдал, хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд оролцох боломжийн талаар судалгаа хийж 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Хорооны дарга, орон тооны гишүүдэд танилцууллаа.


Үнэт цаасны газар тайланд хугацаанд “Эс Жи Эс”, “Превалент”, “Рескап секьюритис” ХХК-иудад брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн зэрэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, “Монет”, “Эс энд ти секьюритис” ХХК-иудад хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны төрлийг нэмж, “Эрдэнэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, “Гендекс”, “Ди Си Эф” ХХК-иудын андеррайтерийн үйл ажиллагааг хүчингүй болгож, “Алтанхоромсог”, “Тэнгри секьюритис”, “Өндөрхаан” ХХК-иудын үйл ажиллагаа эрхлэлийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, “Арга инвест”, “Блүмсбюри секьюритис”, “Сан лав мэд”, “Зэргэд”, “Санар”, “Ханш инвест”, “Глобаль ассет”, “БАТС”, “Эм Ай Си Си”, “Бидисек”, “Монгол секьюритис”, “Гендекс”, “Дэлгэрхангай секьюритиз”, “Мэргэн санаа”, “Булган брокер”, “Монет”, “Монсек”, “ТТСек”, “ҮЦТТТХТ”, “Зюс капитал”, “Таван богд”, “МХБ”, “Фронттиер”, “Си Си Пи” зэрэг ХХК-иудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

“Эф Си Экс”, “Нортонсек”, “Эм даблью Ти Эс”, “Зюс капитал”, “Фронттиер”, “Ворлдкей”, “Монет”, “Глобаль ассет”, “Евроазиа капитал Монголиа”, “Ханш инвест” ХХК-иудын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянаж, брокер дилерийн компанийн холбогдох өөрчлөлтийг Хорооны хуралдаанар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

Үйл ажиллагааны цар хүрээг хүрээг өргөжүүлэх зорилгоор салбар байгуулах шийдвэр гаргасан, оноосон нэрээ өөрчлөх тухай хүсэлтийг гаргасан “Би Ди Сек” ХХК-д салбар нээх, “Алтан сан”, “Ворлдкей” ХХК-иудын оноосон нэрийг өөрчлөх шийдвэр тус тус гарсан байна.

Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан 49 компани бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2-оор нэмэгдэж, 1 компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон байна.

## Мэргэжлийн оролцогч байгууллага



Санхүүгийн тайланд үндэслэн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж ажиллаа. Энэ ажиллагаанд нийт 143 ХК, 49 мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж, 49 мэргэжлийн байгууллагад тайлангийн хариу явуулаад байна.

Мэргэжлийн байгууллагын тухайд тайлант хугацаанд Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв болон брокер, дилерийн компаниудын санхүүгийн тайлан тэнцлийг улирал бүр хүлээн авч зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байдалд дүн шинжилгээ хийн илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар холбогдох үүрэг даалгавар, зөвлөгөөг өгч ажиллаа. Үүний хамт тус газрын хүрээнд нийт мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хийж, тусгайлсан хавтсанд эх баримтыг хавтаслан хадгалах ажлын горимыг нэвтрүүлж ажиллаа.

Мөн мэдээллийн сангийн нэгдсэн журамд заасны дагуу нийт мэргэжлийн байгууллагуудаас ирүүлж буй бүх мэдээллүүдийг нэгтгэн мэдээллийн санд оруулж нийт 50 мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлангийн 2010 оны улирал бүрийн үзүүлэлтүүдийг мэдээллийн сангийн шинэчилсэн программ болох FinA-д оруулж нэгтгэлийг хийлээ.

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн байгууллагууд үйл ажиллагааны дүнд нийт 3.5 тэрбум төгрөгийн орлого олж, 4.7 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, нийт дүнгээрээ 1.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын 53.9 хувийг МХБ, ҮЦТТХТ, Глобаль Ассет, Евроази капитал, Би Ди Сек зэрэг компаниуд бүрдүүлсэн байх бөгөөд өмнөх онтой харьцуулбал орлого 3.7 дахин өссөн бол алдагдал 51 хувиар буурсан үзүүлэлтэй байна. 2010 оны дунд үеэс эхлэн үнэт цаасны арилжааны идэвх сайжирч, нийт зах зээлийн хэмжээнд хувьцааны ханш аажмаар

өссөн ба ялангуяа уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш огцом өссөнтэй зарим талаар холбоотой гэж үзэж байна.

Тайлант онд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын нийт капиталын хэмжээ 46.1 тэрбум төгрөг болсон байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нилээд нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа юм.

Нийт капиталын 69.2 хувь брокер, дилерийн компаниудад оногдож байгаа бол “Монголын хөрөнгийн бирж”, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” гэсэн төрийн өмчит 2 компани үлдсэн 30.8 хувь буюу 14.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшиж байна.

Иргэдийг үнэт цаасны арилжаанд оролцоход зуучлах үүрэг бүхий брокер, дилерийн зарим компани хувьцаа эзэмшигч нарын хувьцааг зөвшөөрөлгүйгээр худалдах, үнэт цаасны ханшид зохиомлоор нөлөөлөх, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох зэрэг зохисгүй үйлдлүүд өмнөх онуудтай харьцуулбал харьцангуй багасч байгаа хэдий ч ирж буй өргөдөл гомдлын дийлэнх нь олон жилийн өмнөх үйлдлүүдтэй холбоотой байсан хэвээр байна.

Тайлант хугацаанд 230 гаруй иргэдээс хөрөнгийг харилцагчийн зөвшөөрөлгүй захиран зарцуулсан гэсэн үндэслэлээр өргөдөл гомдол гаргажээ. Дээрх өргөдөл, гомдлын мөрөөр зохих шалгалтыг хийж захирагааны журмаар 20 гаруй харилцагчийн 2716 хувьцаа болон 432,000 төгрөгийг дансанд буцаан байршуулж гомдлыг барагдуулж ажилласан байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэн явуулж буй “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” /ҮЦТТХТ/ ХХК-д 2010 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар нийт 560,544 хувьцаа эзэмшигчдийн данс бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 449,149 харилцагч буюу 80 хувь нь дансаа нээлгэсэн, 111,395 харилцагч буюу 20 хувь нь дансаа нээлгээгүй байдалтай байна.

Өмнөх онтой харьцуулбал нийт нээгдсэн иргэдийн дансны монгол иргэдийн данс 1.9 хувиар, гадаад иргэдийн данс 34 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол хуулийн этгээдийн дансны тухайлбал, дотоодын хуулийн этгээдийн данс 7.5 хувиар, гадаадын хуулийн этгээдийн данс 28.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх гадны байгууллага, иргэдийн сонирхол өсч байгааг харуулж байна.

Харилцагчдын дансны бүтэц		2009 он	2010 он	Дансны өсөлт /ширхэгээр/	Дансны өсөлт / хувиар/
Иргэн	Монгол	442,575	447,517	4,942	1.9
	Гадаад	627	841	214	34.0
ААН	Монгол	656	705	49	7.5
	Гадаад	67	86	19	28.4




Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй нийт 336 хувьцаат компаниас 19 компани 361,723,269.34 төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг тараасан бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад тараасан ногдол ашгийн үнийн дүн 31 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

2010 оны эцсийн байдлаар нийт 336 ХК-ийн 2,734,535,613 ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас төрийн өмчит хувьцаат компанийн 1,854,363,339 ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаа ба 4 компанийн 352,964 ширхэг компанийн бонд бүртгэлтэй байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй компанийн тоо 17 компаниар буурсан ба үүнд хязгаарлагдмал хариуцлагатай компани болж хэлбэрээ өөрчилсөн компаниуд ихэнх хувийг нь эзэлж байна.

### Бүртгэлтэй хувьцаат компани



2010 онд “Авто тээвэр 28”, “Өгөөж сүмбэр”, “Хайлааст” “Цацрал мон”, “Илч архангай”, “НИК”, “СББ”, “Хаш орд”, “Ардын эрх” зэрэг 9 ХК-ийн гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хассан байх ба “Шарын гол” ХК-ийн хяналтын багцын хувьцааг эзэмшигчдээс ирүүлсэн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн хувьцааг худалдаж авахаар гаргасан саналыг зохих хууль, журмын дагуу хянаж худалдаж авах доод үнийг тогтоон Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлээ.


“Монгол базальт”, “Туул сонгино усны нөөц”, “Монад”, “НИК”, “Анод”, “Монфрэш шүүс” ХК-иудын гаргасан тодорхой хэмжээний энгийн хувьцаа, “Их барилга төсөл 360”, “Анод бонд”, “Бүтээн байгуулалт”, “Нийслэл өргөө” зэрэг тодорхой хэмжээний өрийн бичгүүд зэрэг үнэт цаасуудыг дэлгэрэнгүй бүртгэлээс хасах асуудлыг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

2010 онд бүртгэлээс хасагдсан нийт 13 ХК-ийн нийт 5,528,023,627.07 төгрөгийн ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төлбөр тооцооны төв байгууллагад шилжүүлүүлсэн байна.

“Монголиа девелопмент ресорсес”, “Хай би ойл”, “Нако түлш”, “Шарын гол” ХК-иудын нэмж үнэт цаас гаргахаар ирүүлсэн хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу хянан шийдвэрлэсэн бөгөөд Хорооны хуралдаанаар “Хай би ойл”, “Нако түлш” ХК-иудын нэмж үнэт цаас гаргах асуудлыг зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн байна.


2010 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 241 удаагийн арилжаа явагдаж, 24,169 үнэт цаасны хэлцлээр 62,212,295 ширхэг үнэт цаас арилжигдиж 87,509,741,022 төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээ хийгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 26.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Үнэт цаасны арилжааны үнийн дүн /тэрбум.төг/**




Зах зээлийн үнэлгээ өмнөх оны эцэст 620.7 тэрбум төгрөг байсан бол 2010 оны эцэст 1329.9 тэрбум төгрөг буюу 1.3 их наяд төгрөгт хүрч 2 дахин хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш их хэмжээгээр өссөнтэй холбоотой юм.

Зах зээлийн үнэлгээ /тэрбум.төг/



Хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй, хамгийн өндөр хөрвөх чадвартай 20 компанийн ерөнхий хандлагыг харуулж буй ТОП-20 индекс 2010 оны эхний байдлаар 6,242.40 нэгж байсан бол оны эцсээр 14,424.6 нэгж болж хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индекс 8,182.2 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна.

ТОП-20 индекс



Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих ажлын хүрээнд гүйцэтгэсэн хяналт шалгалтын талаар:

Тус газар нь тайлант хугацаанд үнэт цаасны мэргэжлийн оролцогчид болон хувьцаат компаниудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөөгөө удирдлага болгон ажиллаа.

Тайлант хугацаанд Дорнод, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Баян-өлгий Төв аймгууд болон Улаанбаатар хотын 57 ХК-д, ногдол ашгийн тараалтын асуудлаар 14 ХК-д, мэргэжлийн оролцогч 49 ХХК-д тус тус үзлэг, шалгалт хийсэн байна. *Үзлэг, шалгалт хийгдсэн байгууллагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгдүгээр хавсралтад хүснэгтлэн тусгалаа.*

Хяналт, шалгалтын ажлаас онцгойлон дурдвал тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Эрдэнэт инвест” ХХК-ийн ХОС-гийн хэлбэрээр явуулж байсан үйл ажиллагаанд шалгалт хийж Хорооны 2010 оны 1/1733 тоот албан бичгээр ЦЕГ-ийн Эрүүгийн цагдаагийн газарт эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох дүгнэлт, нотлох баримтуудыг бүрдүүлэн шилжүүлж ажиллаа.

“МИСС”, “Нортенсек”, “Монет” ХХК-иудын зүгээс гадаадын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагуудаар дамжуулан гадаадын зах зээлээс үнэт цаас худалдан авах, худалдах үйлчилгээг үзүүлж буй зуучлалын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийсэн болно.

Дээрх хяналт, шалгалтын ажлын явц болон үйл ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, нэгдсэн танилцуулгыг бэлтгэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналын хамт Хорооны 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцууллаа.

Орон нутагт Дундговь, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгуудад үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын ажилтнуудын хамт томилолтоор ажиллаж үзлэг, шалгалт хийхийн зэрэгцээ тухайн орон нутгийн иргэдэд үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох зорилгоор сургалт, ярилцлагыг зохион байгуулж ажиллаа.

Энэ арга хэмжээний хүрээнд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид байгаа хөрөнгийн үлдэгдлийг шалган баталгаажуулах, данс нээх, ногдол ашиг, ногдол хувийн болон хувьцаа борлуулсны мөнгөн хөрөнгийг эздэд олгох зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Хувьцаат компаниудын хүрээнд тус Хорооны шийдвэрээр арилжааг нь зогсоосон хувьцаат компаниудын асуудлыг судлан, зохих шийдвэрийг гаргаж ажилласан болно. Тодруулбал, өмч хөрөнгө нь үрэгдсэн 55 ХК-ийн тухайн үед удирдаж байсан удирдлага, том хувьцаа эзэмшигчдийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр чигтэй ажилласнаас эхний ээлжинд Нийслэлийн Баянгол дүүрэг, Төв, Баян-өлгий, Увс, Говьсүмбэр, Хөвсгөл аймгуудын “Хөвсгөл”, “Мандал”, “Разноимпекс”, “Тээвэр цагааннуур”, “Авто тээвэр 27”, “Мон сав”, “Мон асар”, “Бат хийц”, “Говь шанд”, “Угтаал төв”, “Атар төв”, “Шар хоолой”, “Алтан үсэг”, “Баянбадрах”, “Дэл баянбулаг”, “Усжуулах”, “Туруун”, “Арилжаа”, “Их нуур”, “Жимст” гэсэн 20 ХК-ийг харъяалах Цагдаагийн байгууллагуудад нь шалгуулахаар шилжүүллээ.

Хорооны шийдвэрээр арилжааг зогсоосон бусад компанийн хүрээнд хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах, үйл ажиллагааг нь сэргээх эсэх, арилжааг нь сэргээх, эсхүл компанийг татан буулгах эсэх асуудлыг зохих хүсэлтэд нь тулгуурлан хянан шийдвэрлэж, зохих шаардлага, анхааруулгыг өгч ажиллаа. Арилжааг нь зогсоосон ХК-иудын талаарх шийдвэрлэлтийн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

2010 оны 12 дугаар сарын байдлаар

Д/д	Арилжааг нь зогсоосон ХК-ийн тоо	ХНХ-аа хуралдуулсан ХК-ийн тоо	Зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилсөн	Арилжаа сэргээх хүсэлт гаргасан ХК	Татан буугдсан
	166	53	22	8	3

Тус газрын зүгээс арилжааг нь зогсоосон хувьцаат компаниудын асуудлыг тодруулан, зохих шаардлагыг тавьж ажилласны дүнд 43 ХК хувь нийлүүлэгчдийн хурлаа хийж арилжаагаа сэргээх эсхүл компанийн хэлбэрийг өөрчлөх, эсхүл татан буулгах шийдвэрээ гарган үнэт цаасны бүртгэлт өөрчлөлт оруулахаар хандаж ажиллаад байна.

Үүнээс 2010 онд “Ардын эрх”, “Хайлааст”, “28-р бааз”, “Цацрал мон”, “Өгөөж сүмбэр”, “Хаш орд” зэрэг нийт 6 компанийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хассан ба “Мөнх үндэс”, “Архуст шунхлай”, “Увс хүнс”, “Сөдөт”, “Батширээт”, “Шарын гол”, “Дарзам” гэсэн 9 ХК-иудын арилжааг сэргээх асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлснээс “Дарзам” ХК-иас бусад компаниудын арилжааг сэргээх шийдвэрийг гаргуулан ажиллаа.

Дээрх үйл ажиллагаатай холбоотойгоор тус газрын зүгээс хэлбэрээ өөрчилж буй болон татан буугдаж буй компанийн хүсэлтийг хянан үзээд жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдох ногдол хувийн нийт 13 компанийн 5 тэрбум 528 сая 23 мянган /5 528 023, 627/ төгрөгийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан зохих нэг бүрийн дансанд байршуулуулж ажиллаа. Мөн зохих журмын дагуу хувьцаагаа компанид худалдахыг шаардах эрхийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж чадлаа.

Түүнчлэн хувьцаат компанийн өмч хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай бүрд буюу бусдад худалдах, барьцаалах, зээл авах зэрэг тохиолдолд гарч буй шийдвэр нь эрх бүхий этгээдээс зохих журмын дагуу гаргасан хуулийн хүчин төгөлдөр шийдвэр мөн эсэх талаар хяналт тавьж ажилласан байна. Тайлант хугацаанд нийт 27 удаагийн тохиолдол гарч зохих хяналтыг хэрэгжүүлж ирлээ.

### **ХК-иудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зайны хяналтын талаар**

2010 оны эхэнд бүртгэлтэй байсан нийт 376 ХК-иас ээлжит хурлын тухай мэдэгдэл, хурлын материалыг Хороонд ирүүлээгүй 212 ХК-ийн нэрсийг хувьцаа эзэмшигчид, харилцагч байгууллагуудад нь зориулсан удирдлагын нь бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг “Өдрийн сонин”-ын 2010 оны 8 дугаар сарын 12-ны дугаарт хэвлүүллээ.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудад зайны хяналт тавьсан талаар болон ХК-иудын 2009 оны жилийн тайлан, 2010 оны хагас жилийн санхүүгийн

тайланг болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2009 оны жилийн тайлан, 2010 оны бүх улирлуудын санхүүгийн тайланг шалган хүлээн авч нэгтгэн, танилцуулга бэлдэж, Хорооны удирдлагад танилцууллаа.

Тайлант хугацаанд нийт 19 ХК 361,723,269.34 төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг тараасан бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад тараасан ногдол ашгийн үнийн дүн 31 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Хороонд үнэт цаасны зохицуулалтын байгууллагууд, хувьцаа эзэмшигчид болон болон бусад иргэд, хуулийн этгээдүүдээс нийт 1742 албан бичгээр хандсан байх бөгөөд Үнэт цаасны газрын зүгээс 813 ширхэг албан бичиг болон газар хоорондын 62 ширхэг албан бичгээр зохих хариуг хүргүүлсэн байна.

“МХБ” ХК-ийн арилжааны мэдээллийн санг өдөр, сар, улирлын ТОП-20 индексийн үзүүлэлт, өдөр тутмын арилжааны бүх хэлцлүүдийн жагсаалт, үнэт цаасны арилжааны сар бүрийн дүн, сар тутмын идэвхитэй арилжаалагдсан 30 үнэт цаас, зах зээлийн үнэлгээ өндөр 30 үнэт цаасны арилжааны мэдээ, ханшийн хэлбэлзэл ихтэй байсан 20 үнэт цаасны талаарх сар тутмын мэдээ, брокер, дилерийн компани бүрийн арилжааны дүн гэсэн үзүүлэлтүүдээр бүрдүүлээ.

Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн журмын дагуу мэдээлэл, хяналтын FinA программ дээр мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар дараах мэдээллүүдийг санд оруулаад байна.

- Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл, түүний өөрчлөлтүүд;
- Мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтүүдийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ;
- Үнэт цаас гаргагчдын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтүүдийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ;
- ХК-иудын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийн биелэлтийн байдал.

Мэргэжлийн байгууллагуудын хувийн хэргүүдийг Архивын тухай хуулийн дагуу цэгцлэх ажлын хүрээнд 257 хадгаламжийн архивын нэгжийг, үнэт цаас гаргагчдын 120 хадгаламжийн архивийн нэгжийг тус тус эмхлэж байгууллагын архивт хүлээлгэн өглөө.

**Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар:**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг СЗХ-ны нэг үндсэн чиг үүрэг гэж заасан байдаг бөгөөд үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай үйлчилж, тавьсан хүсэлт, гомдлыг нь хуулийн хүрээнд бүрэн барагдуулах, улмаар санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нь бий болгох зорилт тавин ажилласан болно.

2010 он гарсаар компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон томоохон хувьцаа эзэмшигч, брокер, дилерүүдийн зүгээс хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг зөрчих, түүнд хохирол учруулах үйлдэл нилээд гарч байв.

Энэхүү үйлдлүүд нь тэдний санал өгөх, ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлах, татан буулгах үед компанийн хөрөнгөөс эзэмшиж буй хувьцаандаа ногдох ногдол хувь авах, хувьцааг нь хувьцаа эзэмшигч болох өмчлөгчийн зөвшөөрөлгүй худалдах, бусдад шилжүүлэх, компанийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, хуульд заасан журам зөрчиж бусдад худалдах, шилжүүлэх, зээлийн барьцаанд тавих гэх мэтээр илэрч байгаа ба олон жилийн өмнө үйлдэгдсэн хэргүүдийг нөхөн шалгаж ирлээ.

Мөн бүртгэлтэй ХК-ийн дийлэнх олонх нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийдэггүй, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангадаггүй, хяналтын багц эзэмшигчид нь бусдынхаа хувьцааг худалдан авахаар санал гаргах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн зэрэгцээ компанийн хөрөнгийг дур мэдэн өөрийн эрх ашигт нийцүүлэн зарцуулах, ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байх зэргээр олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох явдал түгээмэл байна.

Үнэт цаасны газрын Улсын байцаагчид 2010 онд тус Хороонд хандан өргөдөл гаргасан хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээдүүд болон хяналт шалгалтын ажлын дүнгээр нийт 82 Улсын байцаагчийн албан шаардлагыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Үнэт цаасны газрын Улсын байцаагчдын зүгээс 7 удаагийн захиргааны актаар нийт 710,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Тайлангийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэдний зөвшөөрөлгүй биржийн арилжаагаар худалдаж, завшсан үйлдүүдийн талаарх гомдол ихээр ирж байсан бөгөөд энэхүү зөрчлөөс үүдсэн нийт 322 өргөдлийг хүлээн авч Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэж ирсэн болно.

2010 онд “Эрдэнэт инвест” ХОС, “Эрдэнэт” ХХК-ийн удирдлагуудад холбогдох бусдын үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг зөрчиж, их хэмжээний хохирол учруулсан хэргийг урьдчилан шалгаж тогтоон, холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэн харьяалах нутаг дэвсгэрийнх нь Цагдаагийн албанд шилжүүллээ.

Өмнө шилжүүлээд байсан “Мөнхөд” ХХК-д холбогдох эрүүгийн хэрэгт албан ёсны шинжээчийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, холбогдох баримт материалд үндэслэн бусдад учруулсан хохирлын мөнгөн дүнг тогтоосон шинжээчийн дүгнэлт гаргаж, асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхэд шаарлагатай бүх арга хэмжээг авч ажиллаа.

Мөн баримтын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангах үүднээс “Мөнхөд” ХХК-ийн харилцагчдын анхан шатны баримтуудыг гаргуулан авч нийт 24 ширхэг архивын нэгжийг зохих журмын дагуу эмхлэн “МХБ” ХК-ийн архивт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ийнхүү шийдвэрлэсэн Хорооны тогтоол буюу захиргааны актуудыг хуульд нийцсэн эсэх талаар 2010 онд Захиргааны хэргийн шүүх 6 хэргийг, Иргэний хэргийн шүүх 3 хэргийг тус тус үүсгэн шалгасан бөгөөд дээрх хэргүүдийн 2010 онд болсон нийт 21 шүүх хуралдаанд байгууллагыг төлөөлөн оролцсон байна.

Мөн түүнчлэн иргэдийн зах зээлийн харилцаанд оролцох боломжийг бий болгох үүднээс өмнө нь тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниудын харилцагчдыг шилжүүлэх тухай журмын дагуу Хөвсгөл, Архангай, Завхан аймгуудын хувьцаа эзэмшигчдэд үйлчлэх компанийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулж, Архангай, Завхан аймагт “Гүүдсек” ХХК, Хөвсгөл болон Орхон-Уул аймагт “Би Ди Сек” ХК үйл ажиллагаа явуулах бололцоотой болсон байна.

### **Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар:**

Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд тус газраас улсын хэмжээнд мөрдөж буй ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулсан БСШУЯ-нд хүргүүлэн санал, хүсэлтээ тавьж ажиллаа.

Үүнээс гадна, эрх зүйн чиглэлээр зохион байгуулагдаж буй бакалдавр, магистрын болон мэргэшил дээшлүүлэх хуульчдын сургалтад санхүүгийн зах зээлийн талаарх нарийвчилсан хичээл оруулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль зүйн үндэсний төвтэй хамтран ажиллаж байна.

Прайм Инфо төвтэй хамтран 2010 оны 10 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд “Mongolia: Money and Market” Санхүүгийн олон улсын чуулга уулзалтыг анх удаа Улаанбаатар хотноо МҮЭСТО-нд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Монголбанк, Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо албан ёсны дэмжигч төрийн байгууллагаар оролцсон бөгөөд нийт 450 гаруй төлөөлөгчид тус арга хэмжээнд оролцсон гэсэн дүн гарсан байна.

Уг чуулганы хүрээнд “Үнэт цаас хөрөнгийн зах зээлийн талаархи төрийн зохцуулалт, эрх зүйн орчин”, “Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод тулгарч буй тулгамдсан асуудлууд”, “Монголын ипотекийн зах зээлийн тулгамдсан асуудлууд, хөгжлийн боломж”, “Монголын үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн хөгжилд нөлөөлж буй асуудлууд хүчин зүйлс”, “Үл хөдлөх хөрөнгийн төсөлд бондоор санхүүжилт хийсэн жишээ: ололтой ба дутагдалтай талууд”, “Монгол дах үнэт цаасны чанарын асуудал, үнэт цаасны шижилгээ судалгааны чадавхийг хөгжүүлэх нь”, “Монголд институционал хөрөнгө оруулагчдыг бий болгож хөгжүүлэх нь”, “Засгийн газрын болон орон нутгийн бондын зах зээлийн хөгжил, боломж”, “Монголын Хөрөнгийн Биржийн хувьчлал, хөгжлийн асуудал”, “Компаний сайн засаглалыг Монголд төлөвшүүлэх нь”, “Бид бизнесийг үнэлж чадаж байна уу”, “Монголд “Зэрэглэл тогтоолт” /Rating/-ийг хөгжүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ”, “Санхүүгийн бүртгэл, тайлагнал болон аудитын тулгамдсан асуудлууд” зэрэг сэдвүүдээр илтгэл тавигдсан байна.

“Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээл шалгаруулах уралдааныг мэргэжлийн байгууллага, их дээд



сургуулийн хууль эрх зүй, санхүү эдийн засгийн чиглэлийн тэнхим, профессорын баг, эрдэмтэн, судлаач, оюутнууд болон сонирхогчдын дунд 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зарлаж, дүнг гаргалаа.

Эдгээрээс бусад олон нийтэд чиглэн зохион байгуулсан болон оролцсон арга хэмжээг дурдвал:

- АХБ-тай хамтран Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, хөрөнгийн зах зээлийн тухай гарын авлага, ханын зурагт хуудас зэргийг хэвлүүлж ажилдаа ашиглаж байна.

- 2010 онд АХБ-тай хамтран нийтийг хамарсан “Иргэдийн санхүүгийн боловсролд” өдөрлөгийг Баян-өлгий, Дорнод, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл аймгийн төвүүдэд болон Улаанбаатар хотын Баянгол, Сүхбаатар дүүргүүдэд тусгай хөтөлбөрөөр зохион байгууллаа. Уг өдөрлөгийн үеэр 956 хүнд зах зээлийн талаар мэдээлэл хүргэж, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулж, иргэдийн сонирхсон асуудлуудаар зөвлөгөө өгч, танилцуулга, лавлагаа, зөвлөмжийн эмхэтгэлийг тараан сурталчилсан болно. Дээрх арга хэмжээний талаар тухайн орон нутаг, нутаг дэвсгэрийн телевиз, радиогоор нэвтрүүлэг бэлтгэгдэж гарсан болно.

- Газрын удирдлагуудаас “Би ТВ”, “UBS”, “Монгол телевиз”, “Си 1” телевизүүдээр цацагдсан нэвтрүүлгүүдэд оролцож СЗХ-ны хийж гүйцэтгэж буй ажлуудын талаар болон зах зээлийн нөхцөл байдлын талаар ярилцлага, “ТВ 25” телевизээр шууд ярилцлагад оролцож, хөрөнгийн зах зээлийн цаг үеийн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл хийж, үзэгчдийн сонирхсон асуултад хариулсны дээр “Зууны шуудан” сонин, “Хөрөнгийн зах зээл” сэтгүүлд 5 удаа ярилцлага өгч, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар сурталчлав.

- Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаар өөрийн байгууллагын вэб хуудаст мэдээлэл бэлтгэн байршуулсан.

- Үнэт цаасны зах зээл дээр ажиллагсад зориулсан семинар, уулзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар зохион байгууллаа.

- КТМС-ийн ахлах курсын оюутнуудын дунд 2010 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан “Үнэт цаасны зах зээл” сэдэвт уралдаанд онол арга зүйн болон сургалтын материал, гарын авлага, материалын туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

- Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн магиструудын дунд компанийн засаглалын асуудлаар, Шихихутаг дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудын дунд үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын талаар тус тус лекц уншсан байна.

- Улсын бүртгэлийн газрын хяналтын байцаагчдын улсын зөвлөгөөн дээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байцаагчид, Авилгатай тэмцэх газрын мөрдөн байцаагчдын дунд өөрийн газрын чиг үүрэг, үнэт цаасны зах зээлийн харилцааны талаар лекц бэлтгэн уншлаа.

- 2010 оны 11 дүгээр сард ТӨХ, КЗХТөвтэй хамтран төрийн өмчит хувьцаат компаниудын ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлуудын дунд компанийн сайн засаглалын асуудлаар сургалт зохион байгууллаа.

- USAID байгууллагаас 2010.05.28-ны өдөр Хэвлэлийн хурээнд зохион байгуулсан нээлттэй дугуй ширээний ярилцлагад оролцсон.

- Монгол улсад мэдлэгт суурилсан эдийн засгийн төлөвшүүлэх нь сэдвээр МУШУТИС-иас зохион байгуулсан олон улсын бага хуралд “Санхүүгийн зах зээлд мэдлэгт суурлисан чиг хандлагыг нэвтрүүлэх нь” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлээ.

- 2010.05.06-ны өдөр “Улаанбаатар” ЗБ-ын хуолын танхимд “Монгол улс дахь санхүүгийн салбарын үнэлгээ ба хөрөнгийн зах зээлийн шинэчлэл” олон улсын семинарыг зохион байгууллаа.

Үнэт цаасны зах зээл дээр ажиллахыг хүсэгчдэд анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөрөнгийн биржийн сургалтын төвөөр дамжуулан, мэргэжлийн эрх олгох сургалтыг СЗХ-ны сургалтын хөтөлбөрийн дагуу тус тус 1 удаа зохион байгууллаа. Сургалтын агуулга, чанарт онцгой анхаарч, шинэчлэн сайжруулсан бөгөөд 2 хоног байсан үргэлжлэх хугацааг нь 14 хоног болгон сунгаж суралцагчдад илүү гүнзгий, илүү өргөн мэдлэг олгох нөхцлийг бүрдүүлсэн юм.

Сургалтыг 2010 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд “Пума империал” ЗБ-д зохион байгууллаа. Уг сургалтад 68 хүн хамрагдсан байх бөгөөд шалгалтын дүнгээр 46 хүн тэнцсэн байна.

### **Газрын ажилтнуудын мэргэжил ур, чадварыг дээшлүүлэх талаар хамрагдсан сургалт семинар:**

Дээр дурьдсан сургалт, семинаруудад газрын ажилтнуудыг хамруулсны зэрэгцээ дараах сургалт семинарт газрын ажилтнууд оролцож, мэдлэг чадвараа дээшлүүлээ. Үүнд:

- USAID ба IFC ээс зохион байгуулсан “Компанийн засаглалын үндэсний сургагч бэлтгэх” сэдэвт сургалтанд 2 хүн;

- ХБНГУ-ын Франкфурт хотод 8 хоногийн хугацаатай хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, удирдлагын тогтолцоо сэдвээр танилцах, туршлага солилцох ажилд 1 хүн;

- Япон улсад FSA-гаас зохион байгуулсан Хөрөнгийн зах зээлийн семинарт 2 ажилтан хамрагдсан;

- АНУ-ын Үнэт цаасны хорооноос 2010.04.19-2010.05.07-ны өдрүүдэд зохион байгуулсан “Үнэт цаасны институтуудын 20-р чуулган”-д 1 хүн;

- 2010.06.23-2010.06.25-ны өдрүүдэд ИБУИНВУ-д зохион байгуулагдсан “Шилжилтийн эдийн засагтай орнуудын хууль эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт сургалтад 2 хүн;

- Сангийн яамны хурлын танхимд 2010.06.16-ны өдөр зохион байгуулагдсан “Засгийн газрын зээлжих зэрэглэл” сэдэвт сургалтанд 1 хүн;

- 2010 оны 6 дугаар сард Чингис ЗБ-д зохион байгуулагдсан “Монголын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох нь” сэдэвт олон улсын бага хуралд 2 хүн;

- 2010.09.21-2010.09.23-ны өдрүүдэд Монголбанкнаас зохион байгуулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь сэдэвт сургалтад 3 хүн, “Bond market” семинарт 1 хүн;

- GTZ-IPAS төслөөс 2010.06.08-2010.06.09-ний өдөр зохион байгуулсан “Олон улсын үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо ба кастодион үйлчилгээ” сэдэвт семинарт 2 хүн;

- GTZ-IPAS төслөөс 9 дүгээр сард зохион байгуулсан “Арилжааны хяналт” сэдэвт семинарт 1 хүн;

- GTZ-IPAS төслөөс 2010.11.03-ны өдөр зохион байгуулсан “Өөрчлөлт шинэчлэлийн менежмент” сэдэвт семинарт 1 хүн;
- 2010.11.04-ны өдөр зохион байгуулагдсан “Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэхэд тулгарч буй асуудлууд” хэлэлцүүлэгт 6 хүн;
- 2010 оны 11 дүгээр сард Иргэний танхимаас зохион байгуулсан “Мөнгөний бодлого” сэдэвт хэлэлцүүлэгт 2 хүн.

### Дүгнэлт:

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн ханшийн бууралт суларч, хувьцааны ханшийн өсөлт нийтлэг байдлаар ажиглагдсан сэргэлтийн жил байлаа. Гэвч өмнөх жилүүдтэй харьцуулбал, ханшийн өсөлт нь дунджаас их байх боловч гүйлгээний үнийн дүнгийн хувьд бага байгаа юм.

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг хүссэн иргэн, хуулийн этгээдийн сонирхол өссөн, зах зээл дэх арилжааны дийлэнх хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзлэх болсон жил байлаа.

Тус газар нь тайлант хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөсөн эрх зүйн орчныг сайжруулах зорилгоо хангаж ажилласан гэж дүгнэж болохоор байна. Гэвч, мэргэжилтнүүдийн мэргэшил, судалгаа болон боловсруулалтын чадварын түвшин болоод ажлын ачааллын улмаас тавьсан зорилгоо богино хугацаанд далайцтайгаар хэрэгжүүлэх бодит боломж хомс ажилласан жил байлаа.

Дээрх хүчин зүйлс нааштай байсан бол ажлын үр дүн өндөр байх боломж байсан болно. Ялангуяа, хууль тогтоомжийг боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх чиглэлээр ажилтнуудын чадавхи шаардлага хангахгүй, ажиллах хүчээр дутагдаж байлаа.

Газрын бие бүрэлдэхүүн хариуцаж буй салбар, асуудлын хүнд хөнгөн, гүйцэтгэх чиг үүргийн хүрээтэй харьцуулбал хэт бага, нэгж ажилтан маш олон асуудал хариуцдаг, тус бүр нь ажиллагааны хугацаа их шаарддаг нь хариуцсан чиглэлээрээ чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдлыг үүсгэж байсныг цохож байна.

Асуудлыг шийдвэрлэхээр удаа дараа хүсэлт тавьж, гадаадын байгууллагаас мэргэжилтэн авахаар Австрали болон ХБНГУ-ын холбогдох байгууллагатай холбоо тогтоон хүсэлтээ тавьж ажиллаа. Зохих ажиллагаа хийгдэж байгаа болно.

Зах зээлийн зохицуулалтын тухайд тайлант жилийн хүрээнд арилжааны бодит хяналт, ханшийн хөөрөгдлийг хянах ажлыг тухайлан зохион байгуулсан, хяналтын програмын эхийг бэлтгэсэн, санхүүгийн тайлангийн нэгтгэлийг шуурхай хийж, баримтын бүрдлийг хангаж ажилласан, шалгалтын арга ажиллагааг дээшлүүлсэн, нийтлэг горимд оруулсан зэрэг шинэлэг санаачлага гарган ажилласан боловч гүйцэтгэлийн үр дүн, чанар, дотоод болон гадаад хүчин зүйлээс, газрын зохион байгуулалт, нэгж мэргэжилтний ажлын сахилга, хариуцлага болон ачааллаас хамаарч онцгой үр дүнг гарч чадсангүй.

Үнэт цаас гаргагч компаниудын тухайд хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг сайжруулах чиглэлээр нэлээдгүй ажлыг өөрсдийн бодит боломжийн хүрээнд

гүйцэтгэсэн боловч хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээ хангалтгүй, албан хаагчдын тоо, төсвийн хүрэлцээ, техник тоног төхөөрөмж дутмаг байдлаас шалтгаалан зарим бэршээлүүд гарч байлаа.

Түүнчлэн, нэгж мэргэжилтний ажлын сахилга, ажлын цаг ашиглалт, ажлын байрны соёл, ажлын хариуцлагын хувьд доголдол ажиглагдаж байсныг тэмдэглэж байна. Холбогдох мэргэжилтнүүдэд зохих сануулга, анхааруулгыг өгч ажилласан бөгөөд цаашид зөрчил, дутагдал гаргасан хэвээр байх тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авхуулж ажиллах чигтэй байна.

Эдгээрээс үндэслэн тус газрын зүгээс удирдлагад дараахь саналыг гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1/ Тус газрын бүтцийг шинээр тодорхойлох, орон тоог дорвитой нэмэгдүүлэх. Ялангуяа, хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал, заавар боловсруулах, нэвтрүүлэх чиглэлээр газрын чадавхийг нэмэх шаардлага байна;

2/ Эрх зүйн чиглэлээр хууль, дүрэм, журам боловсруулах болон бодлого, судалгаа, сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх;

3/ Тус газрын хянан шалгагчдад газар дээр ажиллах боломж, хангамжийн, төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх;